



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2018.03.26 № 6/1030

таний \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г БҮХ ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГЫН ДАРГА,  
СУВИЛАХҮЙН МЭРГЭЖИЛТЭН,  
СУВИЛАХҮЙН АЛБАНЫ ДАРГА  
НАРТ

Г Эрүүл мэндийн сайдын тушаал  
хүргүүлэх тухай

2018 оны “Олон улсын сувилагчдын өдөр тэмдэглэх тухай” Эрүүл мэндийн сайдын A/87 дугаар тушаалыг үүгээр хүргүүлж байна.

Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах бүх талын арга хэмжээг авч, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллана уу.

Хавсралт 4 хуудастай.

ЭМНЭЛГИЙН ТУСЛAMЖИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ХҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Я.АМАРЖАРГАЛ

9087443 / XA0578 1116126516

081394



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 4/87

Улаанбаатар хот


Олон улсын сувилагчдын өдрийг  
тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, "Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрөөс Эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдөр тохиох Олон улсын сувилагчдын өдрийг "Сувилахуйн тусlamж, үйлчилгээнд үйлчилүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хамгаалья" уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
2. Олон улсын сувилагчдын өдрийг "Сувилахуйн тусlamж, үйлчилгээнд үйлчилүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хамгаалья" уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх жишиг удирдамжийг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү арга хэмжээг улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, мэргэжил арга зүйгээр хангаж, ажиллахыг Улсын гуравдугаар төв эмнэлэг /Ц.Төмөр-Очир/-т даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газар /Я.Амаржаргал/-т үүрэг болгосугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



089423

Эрүүл мэндийн сайдын  
2018 оны 03 сарын 23.-ны өдрийн  
4/89 дугаар тушаалын хавсралт

**ОЛОН УЛСЫН СУВИЛАГЧДЫН ӨДРИЙГ “СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭНД ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХИЙГ  
ХАМГААЛЬЯ” УРИАН ДОР ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ЖИШИГ УДИРДАМЖ**

**1. Нийтлэг зүйл.**

Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар сайжруулахад үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалахаас гадна үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хамгаалах асуудлыг хамтад нь авч үзэх шаардлагатай болохыг Олон улсын Engender Health байгууллагаас тодорхойлж, чанар сайжруулах “COPE буюу үйлчлүүлэгч төвтэй, үйлчилгээ үзүүлэгчийн үр дүнтэй тусlamж, үйлчилгээ” –ний аргыг нэвтрүүлж ажиллахыг улс орнуудад уриалсан болно.

Энэхүү аргыг манай улсын сувilaхуйн тусlamж, үйлчилгээнд нэвтрүүлэх сургалтыг 2012 оноос эхлэн улсын хэмжээнд бүсчлэн зохион байгуулж “Сувilaхуйн тусlamж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагаанд “COPE”-ийн арга хэрэгслийг нэвтрүүлэх удирдамж” гарын авлагыг боловсруулж, сувilaгчдын хүртээл болгоод байна.

Энэхүү удирдамжид үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг дараах хүрээнд тодорхойлсон. Үүнд:

Үйлчлүүлэгчийн үндсэн 7 эрх:

1. Ил тод мэдээллээр хангагдах эрх,
2. Тусlamж, үйлчилгээг авах эрх,
3. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнээс сонголт хийх эрх,
4. Аюулгүй үйлчилгээ авах эрх,
5. Хувь хүний нууцлалаа хадгалуулах эрх,
6. Хүндэтгэлтэй, тав тухтай байдалд эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ авах эрх
7. Тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлаа хангуулах эрхийг хангах олон талт арга хэмжээ

Үйлчилгээ үзүүлэгчийн 3 эрх:

1. Дэмжлэгт удирдлагаар хангагдсан байх эрх,
2. Мэдээлэл, сургалт ба хөгжлийн тасралтгүй ил тод, тэгш байдлаар хангагдсан байх эрх,
3. Ажлын байрны сэтгэл ханамж, тусlamж үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай тоног төхөөрөмж ба дэд бүтэцтэй нөхцөлд хөдөлмөрлөх эрх зэрэг багтана.

Үйлчилгээ үзүүлэгчид ээлтэй орчин нөхцөл бүрдүүлснээр бид дэлхийн хэмжээнд, түүнчлэн манай улсын эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудал

болов “Сувилагчийн хомсдол”-ыг бууруулахад хувь нэмэр болно гэж үзэж байгаа юм.

## 2. Зорилго:

Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр Олон улсын сувилагчдын өдрийг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх

## 3. Зорилт:

Эрүүл мэндийн салбарт үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах

## 4. Зохион байгууллагч:

- ЭМЯ, УГТЭ
- ДЭМБ

## 5. Үйл ажиллагаа, хүрэх үр дүн:

Эрүүл мэндийн байгууллагууд энэхүү жишиг удирдамжийг баримтлан “Сувилахуйн тусlamж, үйлчилгээнд үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хамгаалья” сэдэвт ажлыг зохион байгуулж, дүгнэх, энэ хүрээнд дараах нийтлэг арга хэмжээг багтаасан байна. Үүнд:

### 1. Үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах ажлын хүрээнд:

- Үйлчлүүлэгчийн 7 эрхийг хангах чиглэлээр байгууллагын орчны дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлон, хэрэгжилтийг хангаж ажиллах,
- Үйлчлүүлэгчийн хүлээлгийн цагийг багасгах, цаг алдалгүй үйлчилгээ авах цахим бүртгэлийг сайжруулах, үйлчилгээ авах ээлтэй орчныг бүрдүүлэх асуудлын тасралтгүй байдлыг хангах...,

### 2. Үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хамгаалах ажлын хүрээнд:

- Үйлчилгээ үзүүлэгчийн 3 эрхийг хангах чиглэлээр байгууллагын орчны дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлон, хэрэгжилтийг хангаж ажиллах,
- Байгууллагын шийдвэр гаргалт, мэдээллийн ил тод байдал, тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд сувилагч мэргэжилтнүүдийн оролцоог тодорхойлох,
- Үр дүн, бүтээлтэй ажиллаж байгаа сувилагчдыг урамшуулах, нийгмийн асуудалд нь дэмжлэг үзүүлэх ..., зэрэг арга хэмжээ байж болно

### 3. Нийтлэг арга хэмжээнд:

- ✓ “Сувилахуйн тусlamж, үйлчилгээнд үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хамгаалья” сэдэвийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, телевиз, радиогоор сурталчилж, нийгэмд мэдээлэл хүргэх,

- ✓ “Үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалья” сэдэвт “Сувилагчийн нэг өдөр” уламжлалт аяныг зохион байгуулах,
- 4. Сэдвийн хүрээнд улсын хэмжээний нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах.

## 6. Хяналт, үнэлгээ

1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дэргэдэх сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний албад харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж, дүгнэнэ.
2. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн сувилахуйн албаны дарга нар байгууллагынхаа хэмжээнд арга хэмжээг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж, дүгнэнэ.
3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн сувилахуйн албаны дарга нар зохион байгуулсан үйл ажиллагааныхаа зорилго, зорилт, хүрсэн үр дүнг тодорхой тусгасан товч тайланг, “A4” хэмжээний нэг хуудаст багтаан Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт 2018 оны 05 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ.

## 7. Үйл ажиллагааг дүгнэх.

1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дэргэдэх сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний албад харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг шалгаруулан тэргүүний баг, хамт олныг нэгээс гуравдугаар байр эзлүүлэн цалингийн 25 хүртэлх хувиар шагнаж урамшуулах арга хэмжээг авсан байна.
2. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн сувилахуйн албаны дарга нар байгууллагынхаа тэргүүний тасаг, баг, хамт олныг шалгаруулан нэгээс гуравдугаар байр эзлүүлэн цалингийн 25 хүртэлх хувиар шагнаж урамшуулах арга хэмжээг авсан байна.
3. Улсын хэмжээний нэгдсэн арга хэмжээг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах хэлбэрээр зохион байгуулж, хүн амд мэдээллийг ил тод хүргэх арга хэмжээг авна.

ооОоо